

## МОНГОЛ, ОРОСЫН ХАРИЛЦААНЫ ЗАЛГАМЖ ЧАНАР, ШИНЭ ҮЗЭЛ ХАНДЛАГА

Л. Хайсандай\*

Монгол, Орос хоёр нь хөрш орнуудын хувьд олон зуун жилийн харилцааны түүхтэй билээ, Түүхийн энэхүү урт удаан хугацааны явцад хоёр орны харилцаа түүхэн үйл явдлаар дүүрэн байв, Өөрөөр хэлбэл «Монгол, Оросын харилцааны түүх нь манай улсаас аль ч улс оронтой харилцаж ирсэн түүхээс арвин баялаг юм».

Хоёр улсын нэн шинэ үеийн түүхэнд хамрагдах харилцаа нь хуучин Зөвлөлт Холбоот Улс салан задарч ОХУ байгуулагдах хүртэлх БНМАУ ба ЗСБНХУ (1921—1924 онд Монгол Ард Улс ба Зөвлөлт Орос Улс)-ын хоорондын харилцааны хүрээнд хөгжиж ирэв, Энэ нь үндсэндээ 70 жилийн хугацааг багтааж байгаа юм. Үүнийг тухайн цаг үеийн нөхцөл байдал, үйл явцын шинж онцлог, нөлөөлөл хамаарлын үүднээс хэд хэдэн тодорхой үе шат болгон ангилж авч үзэж болох юм, Үүнд; нэгдүгээр үе 1921 оноос дэлхийн хоёрдугаар дайны төгсгөл буюу 1945 оныг дуустал, хоёрдугаар үе -1946 оноос 1960-аад оны дунд хүртэл, гуравдугаар үе 1960-аад оны дундаас 1990-ээд он хүртэлх үеийг хамарч байна, Харин 1990-ээд оноос манай орнуудын хоорондын харилцаа дэлхий дахины үйл явцтай нийтлэг хамааралтайгаар шинэчлэгдэн өөрчлөгдөх болсноор түүний дөрөвдүгээр үе буюу цоо шинэ шат эхлэснийг энд тэмдэглэвэл зохино,

1921 онд Монгол оронд ардын хувьсгал ялж, түүний үр дүнд туурга тусгаар төр улс сэргэж тогтсон билээ. Энэхүү түүхэн үйл явдалд Зөвлөлт Орос Улсын үзүүлсэн бодитой биетэй тусламж дэмжлэг шийдвэрлэх үүрэг холбогдолтой байлаа, Чухамдаа тэр үед шинэ тулгар Монгол Улсыг элбэн ёсоор хүлээн зөвшөөрч, найрамдалт харилцаа тогтоосон анхны орон бол Зөвлөлт Орос Улс байв, Чингэж их, бага хоёр улсын хооронд тэр үеийн хэмжүүрээр эрх тэгш ийм харилцаа тогтсон явдал нь Утга учиргүй зүйл, санамсаргүй тохиолдол биш байсан юм, Энэ нь юуны өмнө, олон зууны турш айлсан хөршилж бие биеэ чамгүй сайн таньж мэдэх болсон түүхэн Уламжлалаас гадна тухайн тэр цаг үеийн нөхцөл байдал, гол хандлага хийгээд цэрэг-улс төр, нийгэм, эдийн засгийн зэрэг хэд хэдэн хүчин зүйл, бодит шаардлага, ашиг сонирхлоос үүдэлтэй билээ, Тиймээс Монгол Улсын хувьд тэр үед гагцхүү умард их хөрштэйгээ цэрэг, улс төр, эдийн засгийн алив салбарт ойртож, хамтран ажиллах, түүний тал бүрийн тусламж дэмжлэгт тулгуурлаж түшиглэхээс өөр арга зам, боломж нөхцөл огт байсангүй, Үүний гол учир холбогдлыг тайлбарлаж хэлвээс; нэгд, Монголын тусгаар байдлыг өмнөд их хөрш нь шууд үгүйсгэж, улмаар өөртөө хавсарган нэгтгэх түрэмгий бодлого явуулан бодитой занал учруулж байлаа, Хоёрт, дэлхийн бусад улс гүрнүүдээс тэрээр газарзүйн хувьд алслагдсан, тээвэр холбоо харилцааны

\* Эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан.

— 125 —

хувьд ярих ч юм үгүй байсан тул тэдгээрийн ашиг сонирхлын хүрээнд баттай орж чадаагүй, гадна нь үлдсэн байв, гуравт; Монголын засгийн газраас АНУ, Япон, Герман зэрэг дэлхийн нөлөө бүхий олон улсад хандаж, нөхөрсөг хэлхээ холбоо тогтоож хөгжүүлэх талаар удаа дараа санал болгосныг тухайн улс гүрнүүд анхаарч үзсэнгүйн дээр тусгаар тийм улс байгаа эсэхэд эргэлзэж түүнийг хүлээн зөвшөөрөхгүй байв, Эцэст нь Монгол өөрөө туйлын буурай эдийн засагтай, боловсрол, эрүүлийг хамгаалах, тээвэр холбоо, орчин үеийн соёл шинжлэх ухааны салбарууд нэн хоцрогдонуу, улс орноо батлан хамгаалах талаар ч хүчин мөхөс байсан бөлгөө,

Тэр үеийн ийм нөхцөл байдлын улмаас шинэ Монгол Улсын бодлого нь Зөвлөлт улстай найрамдалт харилцаа тогтоон хөгжүүлэхэд л гол чиглэжээ, Зөвлөлт Холбоот Улс ч манай тусгаар тогтнолыг бүр анхнаасаа, дараа нь олон жилийн туршид цорын ганцаараа хүлээн зөвшөөрч, зүйл бүрээр дэмжин туслаж байв, Энэ нь Монголын туслаар тогтносон байдлыг бататган бэхжүүлэхэд ихээхэн ач холбогдолтой болсон хийгээд хоёр их хөршийнхөө нэгэнтэй нь ч болов эв найртай аж төрөх, хүчирхэг итгэлтэй түнштэй болж авах эрх ашигт бүрнээ нийцэж байсан, Зөвлөлтийн тухайд гэвэл тэр үеийн дэлхий дахины нөхцөл байдлаас улбаалан «большевик» үзэл суртлынхаа хүрээг өргөжүүлж тэлэх зорилтоо хэрэгжүүлэх болон өөрийн улсын дорнод хэстийн аюулгүй байдлыг хангах явдалд Монголын өргөн уудам газар нутаг бүхэлдээ давхар хаалт буюу «халхавч бамбайн» үүрэг гүйцэтгэх ашиг тустайг нарийн бодож тооцоолсон бодлогын нэгэн алхам байлаа,

1921 оны арваннэгдүгээр сарын 5-нд найрамдалт харилцаа тогтоох тухай хэлэлцээр байгуулсан тэрхүү түүхэн цаг үеэс хойш хоёр улсын харилцаа, хэлхээ холбоо нь 1929 оны «БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын харилцааны үндсэн зарчмын тухай» хэлэлцээр, 1936 оны «БНМАУ, ЗСБНХУ-ын харилцан туслах тухай» протокол, 1946 оны «БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын найрамдал, харилцан туслах тухай» гэрээ, «Эдийн засаг, соёлын талаар хамтран ажиллах тухай» хэлэлцээр, 1966 оны «БНМАУ, ЗСБНХУ-ын хоорондын найрамдал, хамтын ажиллагаа, харилцан туслах тухай» гэрээний үзэл санаа, зарчим дээр тулгуурлан хөгжиж ирсэн замналтай, Цаг үеийн янз бүрийн шалгалт сорилтыг даван гарч, аливаа үед бие биедээ дотно хандаж, харилцан дэмжин туслах бодит ажил үйлсээр баяжиж ирсэн энэхүү харилцааны түүхэн замналын тухай манай орнуудад хэдэн арван ном зохиол, эрдэмтэн судлаачдын олон зуун бүтээл хэвлэгдэн нийтлэгдсэн тул тэр бүхний талаар тодорхой авч үзэх нь утгагүй бөгөөд илүүц юм, Тэгэхдээ 1980-аад оны сүүл, 1990-ээд оны эхэн үеийн олон улсын харилцааны шинэ нөхцөл байдлын дүнд манай хоёр улсын харилцаа шинэ агуулга, шинжтэй болж, шинэ хэлбэр загварт шилжсэнийг бодитой үнэлэн, үнэн зөв ойлгохын тулд уг хэлхээ холбооны замнал, Уламжлалын зарим нэг гол чухал онцлог талыг тодорхой

жишээн дээр товч боловч тоймлон гаргаж тавих нь зүйд нийцнэ хэмээн бодном,

Чухамдаа Монгол, Зөвлөлтийн харилцааны эхлэл, өрнөл нь юуны урьд цэрэг, улс төрийн салбарт биелэлээ олсон бөгөөд түүхэн нөхцөл байдлын хувьд ингэж таарсан юм, Шинэ Монгол Улс бүүр анхнаасаа өөрийн тусгаар тогтносон байдлаа хамгаалж бэхжүүлэх, харийн алив өнгөлзлөг халдлагад ертөхгүй байхын тулд улс орноо батлан хамгаалах талаар ихээхэн анхаарал тавьж байсан бөгөөд цаг үе нь ч тэгэж шаардсан юм, Зөвлөлт Улс Монголд цэргийн зэвсэг техник нийлүүлэх болон боловсон хүчин бэлтгэж өгөх, мэргэжил туршлагатай цэргийн зөвлөх, сургагчдаа ирүүлж ажиллуулах зэргээр туслаж байв, Энэ бүхний үр дүнд Монгол Улсын зэвсэгт хүчин харьцангуй богино хугацаанд бүрэлдэн бэхжиж, улс орноо батлан хамгаалах байдал нь ч дээшилсэн юм,

Цэрэг, батлан хамгаалах салбарт зохих үр ашигтай хамтран ажиллаж ирсэний тод жишээ бол 1939 оны Халхын голын «зарлаагүй дайн» болон дэлхийн хоёрдугаар дайны жилүүдийн үеэр бие биедээ бодитой тусламж үзүүлж хүч хавсран тэмцэж байсан явдал юм,

Тус хоёр орны хооронд 1923 онд худалдааны анхны гэрээ байгуулсан бөгөөд энэ нь манай улсуудын хоорондын худалдаа-эдийн засгийн хэлхээ холбооны эхлэл болсон байна, Зөвлөлтийн худалдааны янз бүрийн байгууллагууд эхлээд Монголын зах зээл дээр гадаад худалдааныхаа үйл ажиллагааг манай хоршоололтой нягт холбоотой эрхлэн явуулсан нь монголд үндэсний худалдааг өргөжүүлж, төв хоршоог санхүү, материаллаг баазын хувьд бэхжүүлж, цаашдаа бие даан ажиллах явдалд үлэмж тус дөхөм болсон юм,

Түүнчлэн тэр үеэс Монгол, Зөвлөлтийн хувь нийлүүлсэн хөрөнгөөр гол төлөв Зөвлөлтөөс олгож байсан зээлийн хөрөнгөөр хамтын үйлдвэр, мөнгө санхүү, тээвэр, холбооны хэдэн арван газрууд (тухайлбал, «ноосон сан», «Монгол транс», «Монгол банк», «Монголсов-бөөнөөр», «Совмонголстрой», «совмонголметалл» зэрэг)-ыг байгуулан ажиллуулж байгаад хожим нь эдгээр газрыг БНМАУ-ын өмч болгон шууд шилжүүлэн өгдөг байв,<sup>2</sup> Эдгээр арга хэмжээ нь тус оронд үндэсний аж үйлдвэрийн эх суурийг тавих, орчин үеийн тээвэр, харилцаа холбооны цэгүүд, барилгын үйлдвэрлэл болон үндэсний банк санхүү, мөнгө зээлийн систем бий болгож хөгжүүлэх тэдгээр салбарын мэргэжлийн боловсон хүчинг бэлтгэж авахад үлэмж ач холбогдлоо өгсөн билээ,

Энэ мэтчилэн Монголын үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэхэд тус дөхөм үзүүлэхийн тулд Зөвлөлт Улсаас хэрэгцээтэй бараагаар хангах, Зөвлөлтөд гаргах, түүхий эдийн үнэд нэмэгдэл олгох мал аж ахуйн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн газруудыг байгуулах, байгалийн баялгийг судлан шинжилж, ашиглахад олон талын туслалцаа дангаар үзүүлж байв. Үүний хамт ийм туслалцаа дэмжлэг нь боловсрол, эрүүлийг хамгаалах, мал эмнэлэг, шинжлэх ухаан, соёлын салбарыг ч хамарсан юм,

Дээр дурдсан гэрээ хэлэлцээрүүдийн дагуу ЗХУ-ын сургуулиудад 1922 оноос тус орны Улс ардын аж ахуйн янз бүрийн салбарт мэргэжилтэн бэлтгэж эхэлжээ, 1930 онд Улан-Үдэд монголын залуучуудыг дээд сургууль, техникумд сурах бэлтгэлийг хангах Монгол рабфакийг нээн ажиллуулсан байна, Монгол рабфак 10 жилийн хугацаандаа 400 мэргэжилтэн бэлтгэжээ, Москва дахь Дорно дахины хөдөлмөрдийн (коммунист) их сургуульд монголоос 229 хүн суралцаж төгссөнөөс гадна Ленинградын Дорнодахины институтэд Монголын сектор ажиллаж байв, 1942 онд Монголд анхны их сургууль Монгол Улсын Их Сургуулийг ЗХУ-ын шууд тусламжтайгаар байгуулсан нь манай дээд боловсролын системийн үүсвэр болов, Тус их сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэх, үндэсний дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэх явдалд үзүүлсэн ЗХУ-ын тал бүрийн тусламжийг мартахын аргагүй билээ,

Монгол оронд шинжлэх ухааны эмнэлгийг дэлгэрүүлж, нийгмий халдварт өвчнийг анагаан хүн амыг бүхэлд нь эрүүлжүүлэх, эмнэлэг-урьдчилан сэргийлэх газруудыг байгуулахад 1926 оноос тус оронд тогтмол ажиллуулж байсан Зөвлөлтийн эмнэлгийн экспедицүүд болон манай засгийн газрын урилгаар ирж ажилласан эмч нар үнэхээрийн их тус нэмэр үзүүлсэн юм,

Түүний зэрэгцээ манай оронд үндэсний театр, кино, ардын урлаг, радио нэвтрүүлэг зэрэг соёл урлагийн олон арван голомт бий болгон хөгжүүлж, тэдгээрт хэдэн зуун жүжигчин, зохиолч, найруулагч, оператор, зураач зэрэг Урлаг соёлын зүтгэлтний бүхэл бүтэн арми үр бүтээлтэй ажиллах болсныг бас Зөвлөлтийн тусламж дэмжлэгтэй шууд холбон үзэхээс өөр аргагүй байна,

Тийнхүү Монгол, Зөвлөлтийн харилцаа, хамтын ажиллагаа нь дайныг хүртлэх үед гол төлөв цэрэг, батлан хамгаалал болон худалдаа, хувь нийлүүлсэн байгууллагуудын хүрээнд зонхилж байсан бол дайнаас хойших үед тэрхүү хүрээнээс халин гарч төрөл хэлбэр нь өргөжин, хэмжээ далайц нь өсөх болсноор тодорхойлогдоно,

Дэлхийн хоёрдугаар дайн дууссаны дараа дэлхийн ертөнц маань эсрэг тэсрэг хоёр үзэл суртлын лагерьт буюу капиталист, социалист гэсэн хоёр системд хуваагдан бие биеийн эсрэг сөрөн зогсох болсон билээ, Ийм нөхцөлд Монгол Улс нь социалист хүрээллийн дунд буюу дэлхийн болон социализмын хоёр их гүрний хооронд орших байрлалын шууд нөлөөгөөр социализмыг зөвхөн чиг баримжаа болгох төдийгүй, энэ чиглэлээр социалист өөрчлөлтүүд хийх зорилт дэвшүүлж хэрэгжүүлэх замыг сонгов, Энэ зорилгод Монгол, Зөвлөлтийн харилцаа, хамтын ажиллагаа үндсэндээ чиглэх болов, Өөрөөр хэлбэл хоёр улсын хооронд цэрэг, улс төрийн холбоо урьдын адил үргэлжилэн гүнзгийрэхийн зэрэгцээгээр Монгол орны үйлдэрлэх хүчнийг хөгжүүлэх, нийгэм, эдийн засгийн дэвшлийг хангах чиг хандлага хамтын ажил-

лагаанд гол байр эзэлсэн байна, Үүнд тухайлбал худалдааг авч үзье.

Хоёр орны хоорондын худалдаа дэлхийн II дайны хүнд үед ч амжилттай хөгжиж улс ардын аж ахуйн болон хүн амын тухайн үеийн зайлшгүй хэрэгцээг хангахад чухал үүрэг гүйцэтгэж байсан юм,

Хоёр орны хоорондын худалдаа жилээс жилд өргөжиж ирсэн нь эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэж байгааг харгалзан 1957 оны 12 дугаар сарын 17-нд Засгийн газруудын хооронд Худалдааны гэрээг байгуулсан юм,

Хоёр тал эдийн засгийн хамтын ажиллагаатай холбогдох бүх асуудлаар нэн тааламжтай нөхцөлийг харилцан бие биедээ олгож байх болон өөрсдийн нутаг дэвсгэрт оруулах, гаргах бүтээгдэхүүнд ногдуулах гаалийн татвар нь аль нэг гуравдагч улсын бүтээгдэхүүнд ногдуулах гаалийн татвар бусад хураамжаас илүүгүй байхын зэрэгцээ өөр журам буюу илүү хүндрэлтэй ёс горимд тэдгээрийг хамааруулахгүй тухай уг гэрээнд заасан билээ,

Энэ гэрээний үндсэн дээр бараа гүйлгээ, төлбөрийн тухай таван жилийн хэлэлцээр, жил бүрийн протоколыг байгуулж ирсэн болно,

Хоёр орны хоорондын бараа гүйлгээ жил бүр өсч ирсэн бөгөөд манай гадаад худалдааны нийт бараа гүйлгээнд ЗХУ-ын эзлэх хувийн жин 1981 онд 85 хувь болж өссөн юм,

Дайны дараа Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн байгууллага нийгэмлэг үргэлжлэн үйл ажиллагаагаа явуулах юмуу шинээр нэмж байгуулагдаж байв, Жишээлбэл, 1949 оны зургадугаар сард Наушка-Улаанбаатарын хооронд төмөр зам барьж байгуулан, ашиглах тухай БНМАУ, ЗСБНХУ-ын Засгийн газрын хэлэлцээрээр хоёр улсын хувь нийлүүлсэн «Улаанбаатар төмөр зам» нийгэмлэг байгуулахаар тогтжээ, Төмөр зам нь тус Улсад орчин цагийн техникжсэн тээврийн нэгдсэн систем бүрэлдэн тогтох үндэс болсон юм, Тийнхүү ЗХУ-ын хүч хөрөнгөөр 1949 онд Наушка-Улаанбаатарын хооронд 402 км төмөр зам, 1954 онд Улаанбаатар-Сайншандын хооронд 700 км төмөр зам тавигдаж ашиглалтад орсон юм, Улмаар Монгол-Зөвлөлт-Хятад гурван этгээдийн хэлэлцээрээр 1956 онд БНХАУ-ын төмөр замтай холбосон юм, Төмөр замын дагуу өртөө, зөрлөг, зүтгүүрийн засварын газар, цахилгаан станц, орон сууцны олон барилга барьж цоо шинэ хот суурингууд бий болсон, Энэ төмөр зам баригдсанаар ЗХУ болон Европ, Азийн орнуудтай тээврийн шууд харилцаатай болсон нь улс ардын аж ахуйд асар их эч холбогдолтой болсон юм,

Дайнаас хойших жилүүдэд тухайлан аж үйлдвэрийн салбарт л гэхэд ЗХУ-ын сэнхүү, техникийн тусламжийн дийлэнх нь түлш, цахилгаан эрчим хүчний болон уул уурхайн боловсруулах объектуудыг шинээр байгуулах ба өргөтгөхөд зориулагдаж байв, Жишээ нь; 1960 он гэхэд манай улс жилд 600 гаруй мянган тонн нүүрс, 108 сая киловатт-цаг цахилгаан

эрчим хүч үйлдвэрлэдэг болоод байсан бол 1989 онд 7 сая гаруй тонн нүүрс, 3 миллиард гаруй киловатт-цаг цахилгаан эрчим хүч үйлдвэрлэж байв.<sup>6</sup>

Мөн 1957 онд Зөвлөлт засгийн газар Монголд байгуулсан нефть олзворлох ба боловсруулах үйлдвэр, уулын олзворлох «Сов монголметалл» нийгэмлэгийн үйлдвэрүүдэд оруулсан өөрийн хувийг Монголын талд шилжүүлэн өгчээт, Бас ЗХУ-аас Монголын хөдөө аж ахуйд үлэмж машин техникийг нийлүүлж атрын сангийн аж ахуйнууд болон гурилын үйлдэрүүдийг байгуулж өргөтгөхөд дэмжлэг үзүүлснээр тус орон үр тарианы хэрэгцээгээ өөрийн үйлдвэрээр хангах болсноор барахгүй зарим үед гадаадад гарган худалддаг байв. Үүнээс гадна орон сууцны барилга, нийтийн ахуйн үйлчилгээ, соёлын газруудыг барьж байгуулах, хүн амыг эрүүлжүүлэх, төрөл бүрийн мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэх зэрэг олон арга хэмжээг гол төлөв Зөвлөлт Улсын санхүү, зээлийн тусламжинд түшиглэн хэрэгжүүлсэн байна.

Тэдгээрийн дунд 1950-иад оноос эхлэн гучаад жилийн дотор манай үйлдвэрлэх хүчний гол элемент хүн амын тоо хоёр дахин өсч, аж байдал нь үлэмж дээшлэв, Бичиг үсэг үл мэдэх явдал үндсэндээ арилж, сургуулийн насны бүх хүүхэд бүрэн бус дунд боловсролд хамрагдаж, тусгай дунд ба дээд боловсролтой мэргэжилтэн, техник мэргэжлийн боловсон хүчин үлэмж нэмэгдэж, эрүүлийг хамгаалах ба соёлын газруудын материаллаг бааз бэхжсэнээр монголчуудын соёл, боловсролын түвшин хөгжиж байгаа орнуудын дотор тийм ч их доогуур орохооргүй хэмжээнд хүрсэн гэж хэлэх бүрэн үндэстэй,

Түүнчлэн Монгол, Зөвлөлтийн хамтын ажиллагааны нэг гол хэлбэр бол ЗХУ-ын зээлийн тусламж байв, Жишээлбэл, хөрөнгө оруулалтын гуравны нэг, барилга байгууламжийн 60 орчим хувь нь ЗХУ-ын зээл байлаа<sup>8</sup>,

Түүний хамт хоёр орны хамтын ажиллагаанд зөвлөлтийн буцалтгүй тусламж чухал үүрэг холбогдолтой байв, Үүнийг дор дурдсан хүснэгтээс харж болно,

ЗХУ-аас 1960-1986 онд БНМАУ-д шууд тусламжийн шугамаар үнэ төлбөргүйгээр бэлэг болгосон барилга байгууламж, тоног төхөөрөмж<sup>9</sup>

№; Барилга, төхөөрөмжийн нэр : тоо ; үнэ (сая, рубль)

|  |    |      |
|--|----|------|
| 1, Хуримын ордон                                     | 1  | 1,1  |
| 2, МҮЭ-ийн соёлын төв ордон                          | 1  | 5,24 |
| 3, Бүрэн дунд сургууль (аймаг хотуудад барьсан)      | 10 | 39,1 |
| 4, Хүн эмнэлгийн цогцолбор барилга                   | 8  | 18,3 |
| 5, Шинжлэх ухаан ба техникийн төв ордон              | 2  | 19,5 |
| 6, Байшин үйлдвэрлэх комбинат (Улаанбаатар, Дарханд) | 2  | 42   |

|  |                |
|--|----------------|
| 7. Бэлгийн орон сууц 150000 ам, метр талбайтай,  | 70             |
| 8, ТелевизиЙн алс дамжуулах шугамын барилга, тоног төхөөрөмж   | 122,3          |
| 9. Сүү тосны завод, мал аж ахуйн машинт станц, хашаа хүдгийн барилга. төхөөрөмж  | 80             |
| 10, Манай барилгын байгууллагыг бэхжүүлэхэд олгосон тоног төхөөрөмж, мэргэжилтний зардал                                     | 140            |
| 11, Халх гол, Алтанбулагт хөшөө дурсгал музей байгуулахад олгосон зардал   | 1,1            |
| 12, Геологи шинжилгээний ажилд (тоног төхөөрөмж, мэргэжилтэн)  | 4,8            |
| 13, Ган гачиг, зуд болон усны үерийн аюулын үед өгсөн малын тэжээл, малчдын хувцас, зам гүүрийн төхөөрөмж материал, шатахуун | 5,5            |
| 14. Дэлгүүр болон хүүхдийн сүүний газрийн төхөөрөмж  | 0,9            |
| 15, Ард иргэдийг нийгмийн халдварт өвчнөөс зрүүлжүүлэх ба цаг Уурын алба, зам холбоонд                                       | 77,5           |
| 16, Бэлгийн өргөн хэрэгцээний бараа болон манай экспортын бараанд өгсөн үнийн нэмэгдэл                                       | 509,4          |
| 17, Тусгай тоног төхөөрөмж   | 11,66          |
|  | 9              |
| <b>ДҮН</b>   | <b>1148,44</b> |

— Энэ түүвэрт 1960 оноос өмнө 1987 оноос хойш олгосон үнэ төлбөргүй тусламж ороогүй,

—Манай батлан хамгаалах үйл хэрэгт 1921 оноос хойш бэлэг болгон өгсөн буу зэвсэг, машин техникийн дүн энд ороогүй

—ЗХУ-аас 1960-1986 онд өгсөн бэлгийн нийт 1148,44 сая (1148440000) рублийг тэр үеийн ханшаар бодож тооцоолсон болно,

Энэ мэтээр хоёр орны хоорондын уламжлалт харилцааны он дарааллын бичигтэй холбогдсон олон арван жишээ, тоо баримт тоочиж болно, Тэгэвч энэ жилүүдэд манай орнуудын харилцаанд бүх юм сайн сайхнаар байгаагүй нь мэдээж бөгөөд тэдгээрийн хоорондын харилцаа хамтын ажиллагаанд ч алдсан, оносон зүйлийн аль аль нь бий билээ, Энэ талаар эс өгүүлэн энд нэг зүйлийг онцлон тэмдэглэж дүгнэн хэлэхэд; манай Монгол Улс умард их хөршийнхөө тал бүрийн тус дэмжлэт түшиглэж, түүнтэй түншилж харилцан ажилласан энэ жилүүдийн хамгийн гол чухал үр дүн бол тэрээр бага буурай ч гэсэн бие даасан тусгаар байдлаа олж аван, түүнийгээ улс төр, эдийн засаг, соёлын талаар ямар нэгэн

**хэмжээгээр багатгаж эдүүгээг хүртэл оршин тогтнож ирсэн явдал даруй мөн,**

Иймэрхүү санаа дүгнэлтийг монголын болон гадаадын олон эрдэмтэн судлаач, улс төрч, эдийн засагчид хийж байдгийн ганц жишээг энд зориуд хэлсү, Английн түүхч, зохиолч Тим Себерин «Чингис хааны эрэлд» гэсэн ном бичиж нийтлүүлсэн бөгөөд уг номондоо ... ЗХУ байгаагүйсэн бол өнөөгийн Монгол нь яг л Төвд шиг байх байсан, Хятад нь Төвдөд явуулж буй улс төрийн бодлогоо Монголд мөн л хэрэгжүүлэх байсан биз, Хятад биш Орос нь Монголыг жолоодсоноор Монгол хэмээх ертөнц нэг талаар оросжсон ч гэсэн Монгол Улс болж оршин тогтнож монголчуудад амьсгаа авах цаг зай үлдээсэн юм...»<sup>10</sup> хэмээн тод томруун өгүүлээд «Монгол Улс Хятадын нөлөөнд ороогүй нь туйлын зөв болсон аж»<sup>11</sup> гэсэн чухал дүгнэлт хийснийг дурьдалтай,

1990-ээд оноос эхлэн Монгол, Оросын аль алинд нь болон хоорондын харилцаанд цоо шинэ байдал бий болж эрс өөрчлөлт гарав. Энэ нь юуны Урьд Дорнод, Өрнөдийн хооронд өрсөлдөн сөргөлдөх чиг шугам эцэс болсон буюу «Хүйтэн дайны» үе төгсгөл болсонтой холбоотой юм. Нөгөөтэйгүүр дэлхийн социалист ертөнц бүхэлдээ, түүний дотор манай орнуудад улс төр, эдийн засгийн шинэ тогтолцоо бүрэлдэн тогтох үйл явц өрнөсөнтэй шууд холбон үзэх нь зүйтэй, бөлгөө,

Үүнтэй холбогдуулан ОХУ-ын ерөнхийлөгч Б. Н. Ельциний хэлсэн үгнээс иш татъя, Тэрээр «хоёр тал аль аль нь эдийн засгаа зах зээлийн харилцаанд шилжүүлж байгаа болохоор дотоод бодлого нь өөрчлөгдөж байна, Ингэхлээр гадаад бодлого ч өөрчлөгдөхгүй байж болохгүй. Мэдээж манай хоёр орон олон арван жилээр хуримтлуулсан туршлагаа нэгтгэн дүгнэж баймааж нь шинэ харилцаагаа цогцлоох ёстой,

Манай хоёр орны өнгөрсөн үеийн харилцаанд байсан ололт, дутагдал бүхнийг бид өнөөдөр үнэлэн цэгнэж цаашид ямар зарчмаар харилцаагаа «тодорхойлж байна гээд» хамгийн гол нь эдүгээ бид ах дүүгийн ивээлийн ёсоор бус харин олон Улсын харилцааны түгээмэл зарчимд үндэслэн эрх тэгш, бүрэн эрхт, тусгаар тогтносон байдлыг хүндэтгэх ёсоор хоёр талын харилцаагаа хөгжүүлэх юм, Өөрөөр хэлбэл бид харилцан ашигтай бие биеийн үндэсний эрх ашгийг хүндэтгэх зарчмыг гол болгоно, Хуучин Зөвлөлт Холбоот Улсын удирдлагын зүгээс Монголтой харилцахдаа зарим талаар дээрэнгүй хандаж байсныг хэлэх хэрэгтэй, Харин одоо бол ийм явдал хэрхэвч гаргаж болохгүй. Бид их гүрний дээрэнгүй бодлогыг эцэс болгосон<sup>12</sup> хэмээн мэдэгдсэн нь зарчмын ач холбогдолтой.

Хоёр орны харилцааг тийнхүү цоо шинэ загварт шилжүүлж шинэчлэн өөрчлөх үйл явц бүүр эхнээсээ багагүй бэрхшээлтэй тулгарсан, Энэ нь юуны Урьд эхлээд социалист систем задарч, дараа нь ЗСБНХУ өөрөө задарч бүрэлдэхүүнд нь багтаж байсан 15 холбооны бүгд найрамдах Улс тусгаар тогтносон улсууд болон тусгаарлагдаад тэдгээрт болон ялан-

гуяа ОХУ-д улс төр, эдийн засгийн шинжтэй хямрал, зөрчил хурцдаж, хөрш орнуудтай тогтоосон аж ахуйн Уламжлалт янз бүрийн хэлхээ холбооны уяа нь алдууран эрс суларсан буюу бараг тасрахад хүрсэн явдалтай шууд холбоотой байв, ийм нөхцөл байдал нь тухайлан түүний бага хөрш Монгол улсад бүүрч хүндээр туссан юм, Энэнд өөрийн учир шалтгаан бас бий юм, Үүнд юуны өмнө монгол орны улс ардын аж ахуйн бүх салаа салбар бүхэлдээ Зөвлөлтийн эдийн засагтай маш нягт холбогдсон, түүний эрхшээлд автагдсан байсан хийгээд Монгол улс газрын тосны бүтээгдэхүүн, түлш эрчим хүч болон улс орны амьдралын амин чухал олон зүйлээр зөвхөн Хойт их хөршөөсөө бүрэн хараат байдалтай болсон явдал юм, Тэгээд ч Зөвлөлт Улс олон жилийн турш Монголын гадаад эдийн засгийн харилцаанд үнэмлэхгүй давуу байр суурь, эрх дархтай байв, Энд ганц жишээ дурдахад Монгол шиг жижигхэн орны хувьд ЗХУ-тай хийж байсан худалдаа л гэхэд нийт хэмжээ нь тэр үеийн ханшаар 1,66 тэрбум рубльд хүрч манай гадаад худалдааны эргэлтийн 90 шахам хувь, Зөвлөлтийн нийт худалдааны 1.2 хувийг эзэлдэг байлаа<sup>13</sup>,

Нөгөөтэйгүүр ялангуяа 1960-иад оноос эхлэн хоёр орны худалдаанд үнэ тарифын тэгш бус, хоцрогдсон арга механизм үйлчилдэг болсон, Зөвлөлтийн экспортын бараа, машин тоног төхөөрөмжийн үнэ байнга өсөн нэмэгдсээр байхад Монголын экспортын барааны үнэ дэлхийн зах зээлийнхээс үлэмж доогуур байсан зэрэг нь өрийн асуудал үүсч ужиграх нэг хөрс суурь болжээ, Энэ нь чухам үнэндээ хоёр улсын бүх талын хамтын ажиллагааг зүйл бүрээр хөгжүүлэх нь Монголын хувьд зайлшгүй шаардлагатай бөгөөд ихээхэн үр шимтэй гэж гуйвалтгүй итгэж, өөрийн байгалийн эрдэс баялаг, хөдөө аж ахуйн түүхий эдийг ЗХУ-д сэтгэл харамгүй гаргасаар ирсэн атлаа дааж давшгүй өртэй болсон. нөгөө талаас өнгөрсөн хэдэн арван жилийн түүхэн хөгжлийн явцад энэ хэмжээний өрийг төлчихөөр эдийн засгийн чадавхитай болж чадаагүйд харууссан манай олон нийтийн бухимдлыг ч бий болгосон гэж хэлж болох юм. Энэ бүхнээс шалтгаалан тус хоёр орны өргөн цартай, олон талын хэлхээ холбооны хүрээ хэмжээ үлэмж хумигдан хязгаарлагдахад хүрсэн билээ,

Өнгөрсөн үеэс үүдэлтэй энэ мэт сөрөг үзэгдлийг засаж залруулах, хоёр улсын харилцаа, хамтын ажиллагааг шинэ нөхцөлд шинэ зарчмаар хөгжүүлэх талаар Монгол Улс, ОХУ-ын Удирдлага сүүлийн үед багагүй зүйл хийв, Энд юуны өмнө дээд, өндөр хэмжээний уулзалт, яриа хэлэлцээ тогтмолжиж, хамтын ажиллагааны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх, шинэ зуунд чиглэсэн харилцааны улс төр, эрх зүйн үндсийг тавих талаар тодорхой алхмууд хийснийг дурдах хэрэгтэй юм,

Монгол Улсын Ерөнхийлөгч 1993 онд ОХУ-д албан ёсоор айлчилж, хоёр орны хооронд «Найрсаг Харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ» байгуулсан нь Монгол, Оросын

хооронд эрх тэгш, харилцан ашигтай харилцаа хөгжүүлэх эрхзүйн шинэ үндэс суурийг тавив, Энэ айлчлалын үеэр ойлголцож тохирсон зүйл, 30—40-өөд оны үеийн хэлмэгдлийн асуудлаар гаргасан хамтарсан мэдэгдэл зэрэг нь харилцааны өнгөрсөн үеийн сургамжийг зөв үнэлэх, өнөөгийн уур амьсгалыг эрүүлжүүлэх таатай нөхцөлийг бүрдүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой болсон юм,

Удирдлагын дээд түвшинд тохирлцсоныг бататган ойлголцох, харилцааны өнөөгийн болон ойрын ирээдүйн олон асуудлыг шийдвэрлэхэд манай Ерөнхий сайдын 1995 онд хийсэн айлчлал чухал үр дүнтэй болсон билээ, Энэ үеэр хамтын ажиллагааны тухай 10 баримт бичигт гарын үсэг зуржээ, Түүнчлэн хоёр орны Парламент, Засгийн газрын шугамаар олон чухал айлчлал харилцан хийлээ, Үүнээс УИХ-ын дарга, Засгийн газрын шадар сайд, ОХУ-ын холбооны хурлын Төрийн думын дарга Г. Н. Селезнёв, ОХУ-ын Засгийн газрын орлогч дарга О. Д. Давыдов, ГЯЯ-ны сайд Е. М. Примаков нарын айлчлалын ач холбогдлыг хоёр тал өндөр үнэлж байгаа билээ,

Өнгөрсөн богино хугацаанд хоёр улсын төрийн яам, газруудын харилцаа сэргэн идэвхижих хандлагатай болж, хамтран ажиллах тухай зохих гэрээ хэлэлцээрүүд байгуулан ажиллаж байна, Тухайлбал манай улсын Гадаад харилцааны сайд 1992 онд албан ёсны айлчлал хийх үеэр хоёр орны харилцааны олон чухал асуудлаар ОХУ-ын зохих шатны Удирдлагуудтай уулзан санал солилцсоны дээр Монгол Улс ОХУ-ын нутаг дэвсгэрээр дамжин далайд гарах, тээвэр хийх тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулав, Түүнчлэн хоёр улсын Батлан хамгаалах, Хүнс, хөдөө аж ахуй, худалдаа аж үйлдвэр, соёл, түлш эрчим хүч, байгаль орчин, хүн амын бодлого хөдөлмөрийн болон дэд бүтэц, сангийн сайд нар, Дээд шүүхийн дарга, ШУА-ын ерөнхийлөгч, хил, гааль, төмөр замын газрын удирдлагууд Москва, Улаанбаатарт уулзаж, хамтын ажиллагааны баримт бичгүүдэд гарын үсэг зуржээ,

Монгол, Оросын харилцаанд орон нутгийн хүчин зүйл нэн чухал байр эзэлдэг, Бүхнийг Улаанбаатар, Москвад төвлөрүүлэн шийдэж байсан арга барил үеэ өнгөрөөжээ, Одоогоор бүх юм ном ёсоороо жигдэрчихээгүй ч өнөөгийн шинэ нөхцөлд үүрэг холбогдол нь Улам есөх хандлагатай байна, Тус хоёр орон 3485 км урт хуурай газраар, 677 км урт усан газраар хиллэдэгийн хувьд энэ нь онцгой чухал юм, Хил залгаа буху ер нь монгол туургатан бүс нутгуудын хооронд янз бүрийн салбарт, ялангуяа эдийн засгийн чиглэлээр хамтран ажиллах явдал идэвхжих боллоо, Үүний тод жишээ гэвэл сүүлийн үед Монголд Саха (Якут), Халимаг, Буриад, Тува улсын ерөнхийлөгчид, Урал, Эрхүү, Чит мужийн захирагч нар айлчлал хийсэн нь хоёр болон олон талын хэлхээ холбоог бэхжүүлэхэд чухал үйл явдал болов,

Хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааг зах зээлийн эдийн засгийн шинэ нөхцөлд нийцүүлэн хөгжүүлэх, хамтын

ажиллагааны шинэ механизм бий болгох талаар бас ахиц өөрчлөлт гарч байна, Үүнд: 1992 оноос хоёр орны Засгийн газрын хооронд байгуулагдан ажиллаж байгаа худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан-техникийн хамтын ажиллагааны комисс чухал үүрэг гүйцэтгэж байна,

Тухайлбал 1993 оны 7-р сард Красноярскт Засгийн газар хоорондын комиссын II хуралдаан болж, дээд хэмжээний Уулзалтаар тохиролцсон асуудлуудыг ажил хэрэг болгох, салбаруудын хамтын ажиллагааг өргөжүүлэх, цаашид хамтран ажиллах шинэ хэлбэрүүдийг бий болгож хэрэгжүүлэх зэрэг хэд хэдэн чухал асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Мөн хуралдааны үеэр Монгол, Оросын ажил хэрэгч хүмүүсийн анхны уулзалтыг зохион байгуулсан бөгөөд Уг уулзалтыг Уламжлал болгон 1993 оны 11-р сард Улаанбаатарт хоёр дахь Удаагаа хийсэн нь Оросын Красноярскийн хязгаар, Кемеров, Эрхүү, Чит муж, Хил залгаа БНУ-ууд болон Монголын бүс нутгийн ажил хэрэгч хүмүүсийн хэлхээ холбоог эхжүүлэхэд чухал алхам боллоо,

Буриад, Эрхүү муж бол Монголын эртний харилцааны Уламжлалтай бүс нутаг юм, Монгол, Оросын хил залгаа бүс нутгууд эдийн засгийн хувьд хир зэрэг бэхжинэ, тэр хэмжээгээр хоорондоо идэвхитэй үр дүнтэй хамтран ажиллах бололцоо улам нэмэгдэх болно,

Манай хоёр орон зах зээлийн эдийн засагт шилжиж эхэлсэнтэй холбогдуудан худалдаа, эдийн засгийн харилцааны төлбөр, тооцоог 1991 оноос дэлхийн зах зээлийн тухайн үеийн үнээр, чөлөөтэй хөрвөх валютаар хийхээр тохиролцож 1991 оны 2-р сард худалдаа, эдийн засгийн талаар хамтран ажиллах тухай Засгийн газар хоорондын хэлэлцээр байгуулсач, Гэвч хоёр орны алин алинд нь чөлөөтэй хөрвөх валютын нөөц хомс, шилжилтийн үеийн элдэв хүндрэл, бэрхшээлээс шалтгаалан худалдааны хэмжээ эрс буурсаар ирэв,

Монгол Улс, ОХУ-ын хоорондын бараа гүйлгээг хүснэгтээр үзүүлбэл<sup>15</sup>

(сая, ам, доллараар)

| №: Он                 | экспорт | импорт | нийт гүйлгээ |
|-----------------------|---------|--------|--------------|
| 1, 1991               | 233,8   | 238,3  | 472,1        |
| 2, 1992               | 219,7   | 214,3  | 434,0        |
| 3, 1993               | 145,2   | 220,3  | 365,5        |
| 4, 1994               | 89,9    | 128,3  | 218,2        |
| 5, 1995 (эхний хагас) | 82,4    | 94,5   | 178,9        |

Ээ шалтгаанаас манай улс ардын аж ахуйд чухал шаардлагатай урьд нь байнга нийлүүлэгдэж байсан олон нэрийн машин, тусног төхөөрөмж, сэлбэг материал, түүхий эд нийлүүлэгдээгүйгээс ихэнх үйлдэрүүд сул зогсох юмуу бүрмөсөн хаагдахад хүрсэн юм, Энэ нь эргээд бас Монголоос ОХУ-д экспортлох бараанд нөлөөлөв, Түүнээс гадна Монголоос нийлүүлж ирсэн Уламжлалт зарим бараа нь ОХУ-д мөрдөгдөж

эхэлсэн төрөл бүрийн татварт хамрагдах болсноор худалдан авагчийн зүгээс тэдгээрийг авах сонирхлыг ихээхэн бууруулав, Хэдийгээр хөгжиж буй орны нь хувьд Монголын бараанд ногдуулах гаалийн татвараа ОХУ хоёр дахин хөнгөлж байгаа боловч онцгой болон нэмүү өртгийн татварын хэмжээг бодолцоход хивс, савхи, нэхий, үслэг эдлэл зэрэг барааны гэрээний үнэ хэрэглэгчдэд хүрэхэд 56—74 хувиар нэмэгдэх болсон,<sup>16</sup> Энэ байдал нь харилцан бараа солилцоонд муугаар нөлөөлсөн юм,

Хоёр улсын хоорондын худалдаанд өнөөдөр зэсийн баяжмал, нефть, бүтээгдэхүүн гол байр суурь эзэлж байна, Тухайлбал, манай улс 1994 онд 97,5 мян, тонн зэсийн баяжмал экспортлож, 160,0 мян, тонн нефть бүтээгдэхүүн ивпортлоор авч байсан<sup>17</sup> бол 1966 онд 140 шахам мянган тонн зэсийн баяжмал экспортлож, 200 гаруй мянган тонн бензин импортлосон<sup>18</sup> жишээтэй, ОХУ-аас импортлосон барааны 60 гаруй хувийг үйлдвэр-техникийн зоориулалттай бараа, 10 орчим хувийг өргөн хэрэглэсний бараа эзэлж байна<sup>19</sup>

Зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц хоёр оронд өрнөсөн жилүүдэд худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд ихээхэн саад тотгор учирч, худалдааны хэмжээ тийнхүү багассаар ирсэн боловч ялангуяа сүүлийн үед идэвхижин сэргэх хандлага ажиглагдаж байна, Энэ нь хоёр талын аж ахуйн нэгж, байгууллага, хүмүүсийн хооронд шууд харилцаа, бараа солилцоо, хил худалдааны хэлбэрээр хамтын ажиллагаа өргөжиж байгаагаар илэрч байна,

Хоёр орны үйлдвэр, худалдааны төлөөлөгчдийн уулзалтыг тогтмол зохион байгуулж байгаа нь үр дүнгээ өгч байна,

1995 оны дүнгээр манай улсын гадаад худалдааны 50 гаруй хувь нь ОХУ-д ногдож байгаагаас үзэхэд тус улс нь манай худалдааны хамгийн том гол түнш хэвээр байна.

Эрчим хүч, тээвэр, нийтийн аж ахуйн барилга байгууламжийн барилгын ажлыг дуусгах, өөрчилж өргөтгөхөд зориулан ОХУ-аас Монгол улсад 1992 оноос эхэлж олгосон 38,75 сая ам, долларын зээлийн хөрөнгөнөөс одоогоор 90 орчим хувь нь ашиглагдаад байна,<sup>20</sup>

Уулын баяжуулах «Эрдэнэт» үйлдвэр, УБТЗ, «Монголросцветмет» зэрэг өмнө байгуулагдсан Монгол, Оросын хамтарсан үйлдвэр байгууллага эдүгээ ч үр ашигтай ажиллаж байна, Хүнс, хөдөө аж ахуй, зам, тээвэр, холбоо, түлш, эрчим хүчний болон машин механизмын тоног төхөөрөмж засварлах, сэлбэг үйлдвэрлэх чиглэлээр Орос-Монголын хамтарсан үйлдвэр, аж ахуйн байгууллагын тоо 1991 оноос үлэмж нэмэгдэв, Тухайлбал, 1991 онд ийм хамтарсан компани 21, 1992 онд 53, 1993 онд 45 байгуулагдсан жишээтэй, Эдгээрийн дотор Оросын талын 100 хувийн хөрөнгө оруулалттай «Совинвест», 1 «Монгролинтеросервис». Зарубежстрой», «Усибо» зэрэг компаниуд<sup>21</sup> байгуулагдан үр бүтээлтэй ажиллаж байна, Ер нь Монгол, Оросын хооронд худалдаа, эдийн засгийн

хэлхээ холбоог ихээхэн өргөжүүлэн хөгжүүлэх, үр ашигийг нь үлэмж нэмэгдүүлэх нөөц бололцоо, боломж их байгаа авч тэр бүр бүрэн ашиглаж чадахгүй байна, Түүнчлэн энэ талаар хоёр талын ашиг сонирхлыг жигд дээшлүүлэх шаардлагатай байгаа нь ч илт үгүйлэгдэж байна,

Шилжилтийн зовиуртай үеийн нөхцөлд хүмүүнлэгийн болон шинжлэх ухаан, соёлын салбарын хамтын ажиллагааны үр шимтэй ундарга бараг үндсэндээ тасалдав, Эдүгээ ч дээрх салбаруудаар хамтран ажиллах асуудал сэтгэл зовоосон хэвээр байна, Чухамдаа Улс дэмжиж, чиглэсэн зорилгоор хөрөнгө гаргахгүй бол хоёр талын харилцаа, хамтын ажиллагааны энэ чиглэлүүд жинхэнэ ёсоор сэргэж хөл дээрээ босож ирэх нь мөдгүй байна,

Шинжлэх ухаан, техник, соёл, боловсрол, мэдээллийн салбарын хамтын ажиллагааны урьдын, олон жилийн уламжлалыг сэргээж, шинэ нөхцөлд гэрээ хэлэлцээрийн сайн үндэс суурьтай болгосноор үр нөлөөтэй харилцах бүрэн боломжтой, Хоёр талын хамтран явуулж байсан эрдэм шинжилгээ, суурь судалгаа, хамтарсан экспедицүүдийн ажиллагааг шинээр авч үзэж, хамтран ажиллах зарчим, арга барилыг нь өөрчлөх үндсэн дээр сэргээн явуулж ч болмоор мэт санагдана,

Хоёр улсын харилцаанд өнөө үед хурц маргаантай, тэмцэл зрчилтэй, сэтгэл түгшээсэн тийм ноцтой асуудлууд байхгүй боловч зохих шийдэл хүлээсэн, харилцан бодитой хандаж ойлголцон тохиролцоонд хүрэх, цаг алдалгүй шийдвэрлэх ёстой зарим асуудал бий нь мэдээж, Тухайлбал юуны урьд өрийн асуудал байна, 1993 оны дээд хэмжээний уулзалтаар тохиролцсоны дагуу хоёр талд өрийн асуудлыг зохицуулах талаар санал боловсруулж, хэлэлцээ хийх байнгын комиссууд байгуулсан нь 1994 оны 5 дугаар сард Москвад анхныхаа хэлэлцээг хийжээ, Тус хэлэлцээрээр Оросын тал зээлийн тооцоог нийлэх, янз бүрийн үед байгуулсан бүх хэлэлцээрийг нэгтгэж, зээлийн өрийг чөлөөт валютад шилжүүлэх, өрийн асуудлыг зохицуулах арга хэлбэрийг тохирч хэлэлцээр байгуулах санал дэвшүүлсэн, Харин Монголын тал 1990-аад оноос хийсэн удаа дараагийн яриа хэлэлцээний үр дүнд хүрсэн түвшинг хүндэтгэн үзэж баримтжуулан цаашдын хэлэлцээний үндэс суурь болгох, үүнд эдийн засаг, шинжлэх ухаан - техникийн хамтын ажиллагааны Засгийн газар хоорондын комиссын 1990 оны 28 дугаар хуралдаанаар «Монголын зээлийн өрийг чөлөөт валютад шилжүүлэн тооцох итгэлцүүрийг тогтоохдоо хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны онцлог, ялангуяа үнийн гажуудлыг тусгах», мөн шинэ ийм комиссын 1992 оны анхдугаар хуралдаанаар «хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд гарч байсан үнийн зөрүү, бусад сөрөг үр дагаврыг тооцож, тохиролцоонд үндэслэн хоёр орны худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагаанд тухайн үед гарсан үнийн гажуудлыг арилгах, зээлийн зориулалт бүтцийг харгалзан зарим хэсгийг тусламжийн хэлбэрээр тооцох, үлдсэн хэсгийг хөн

гөлөлттэй итгэлцүүр хэрэглэн чөлөөт валютад шилжүүлэх зэрэг санал дэвшүүлсэн байна, Дээрх саналуудыг нягтлан үзэж, зээлийн өрийг барагдуулах хугацааг хойшлуулах, хүүг хүчингүй болгох зэрэг тохиролцоонд хүрээд буйн дээр цаашдаа өрийн төлөх, хэсгийн бодит тоо хэмжээг Монголын өнөөгийн эдийн засгийн хүч чадалд хүлээн авч болохуйц түвшинд тогтоох нь өрийн асуудлыг аль аль талдаа ашигтайгаар зохицуулж болох тухай Удаа дараа тэмдэглэсээр байгаа билээ, Үүнийг аль болох түргэн хугацаанд харилцан тохирч, нааштай шийдвэрлэх нь хоёр орны хамтын ажиллагааг цаашид бүх талаар өргөжүүлж хөгжүүлэхэд дарамт саад тотгор болж буйг арилгаад зогсохгүй манай хоёр улс хоорондоо болон өөр бусад олон улс оронтой харилцах үйл хэрэгт үнэнхүү итгэлцлийг бэхжүүлэхэд ихээхэн тус дөхөмтэй болохсон билээ,

Өөр бусад асуудлын тухайд гэвэл: Хоёр улсын хилийн дэг журмыг сайжруулах, иргэд харилцан зорчих явдлыг хялбарчлах, Зөвлөлт (Орос)-ийн цэрэг Монголд байрлаж байсан хийгээд гарсантай холбогдсон асуудлыг зохицуулах зэрэг харилцан тохирч болохуйц асуудлууд бий билээ, Тэдгээрийг шийдвэрлэхэд дийм ч төвөгтэй биш бөгөөд хоёр улсын харилцааны хөгжилд онцын тулгамдсан асуудал болж тавигдаагүй нь мэдээж, Гэвч хойшлуулалгүй шийдэх л ёстой асуудлууд даруй мөн,

Эцэст нь дээр дурдсан дүгнэлт санаагаа бас давтан өгүүлвээс; «ЗХУ, Орос орон (хэрэв үнэхээр эмгэнэлтэй хэлмэгдлийн үеийг эс тооцвол) Монголд муу юм огтхон ч хийгээгүй»<sup>22</sup> бөгөөд түүгээр ч барахгүй бидний Монголчууд үндэстнийхээ хувьд генийн сангаа хадгалан үлдсэн нь Оросын тусламж, дэмжлэгтэй холбоотой хэмээн үздэг юм, Хэрэв хойт их хөршөө түшиглээгүй бол манай улс орон чухам юу болох, ямар янзтай байх байсныг хэн мэдлээ!

Монгол Улсын хувьд олон арван жилийн энэ Уламжлалт Харилцаа, хамтын ажиллагааны ач холбогдол, газарзүйн байршлалыг ямагт тооцон бодолцож, ОХУ-тай бүх талын найрамдалт хэлхээ холбоогоо улам өөдрөгөөр хөгжүүлэх явдал эрхэм дээд эрх ашиг нь мөн,

#### Ашигласан материал

1. П. Энхбаяр, Монгол-Оросын харилцааны зарим асуудлууд, -«1990-ээд оны олон Улсын хандлагууд, Монгол улс -Их гүрнүүдийн харилцаа», 1995 он, 63 дахь тал,
2. Б. Лхамсүрэн, Монголын гадаад орчин, төрийн тусгаар тогтнол, УБ, 1995, 56 дахь тал,
3. К. Малакшанов, Ах дүүгийн найрамдлын алтан хуудаснаас-«Шинжлэх ухаан, амьдрал», 1966, № 4, 7 дахь тал,
4. «Новости Монголии», 1987, № 44,
5. «Дорнодахины судлалын асуудал», 1989, № 1, 50 дахь тал,

- 6, «Хөдөлмөр», 1993, № 1617
- 7, «Монголия», 1986, № 4, 27 дахь тал,
- 8, «Хөдөлмөр», 1993, № 1617,
- 9, «Үнэн», 1990, № 189,
- 10, TIM SEVERIN «IN SEACH OF GHINGHIS KHAN»  
LONDON, 1991, 126 дахь тал,
- 11, Мюн тэнд,
- 12, «Ардын эрх», 1993, № 13,
- 13, «Засгийн газрын мэдээ», 1995, № 37,
- 14, «Ардын эрх», 1993, № 114,
- 15, «Внешняя торговля России», 1993, № 4—5, стр. 49.
- 16, «ЗГМ», 1995, № 38.
- 17, «ЗГМ», 1995, № 38,
- 18, «ЗГМ», 1995. № 179.
- 19, «ЗГМ», 1995, № 38.
- 20, «Правительственные вести», 1995. № 242
- 21, «Ардын эрх», 1994, № 32,
- 22, «Дипкурьер», 1995, № 66. 93 дахь тал,



125-